

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Баасандорж	Дугаар	L173
Оршин суугаа аймаг	Говь-Алтай	Оршин суугаа сум	Баян-Уул
Төрсөн газар	Баян-Уул сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Нийгмийн ажилтан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Нуур могойн хийд	Сүм хийдийн дугаар	ГАБУ 112
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Нуурмогой хийд

2007 оны 8-р сарын 30-ны өдөр. Судалгааны баг Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нийгмийн ажилтан Баасандорж гуйтай уулзаад байна.

Асуулт:- Нуур могой хийдийн тухай ярьж өгнө үү. Энэ хийд хэд орчим оны үед байгуулагдав?

Хариулт:-Шаравдаржаалин хийд энэ сүм мөргөлийн газар нь эхлээд Сангийн далай нуурын хөвөөнд байгуулагдаж, хожим 1881 оны улаан морин жилд Нуур могойд шилжин нүүж ирсэн юм гэнэ лээ. Тэр үед хийд байгуулагдсан үед 40 дуут нэртэй хурал, 40 ламаар хуруулж, Цогчэн ламын хурал сургуулийг байгуулж Шаравдаржаалин гэж нэрлэсэн түүхтэй юм билээ. Энэ засаг Чоймболын 1784-1831 оны үед, 1828 онд Ламрин, засаг Манзуширийн 1832-1855 оны үед, 1861 онд Дүйнхэр дацанд хуруулж, засаг Сономцэрэнгийн үед Мэгзэмийн бүтээл үүсгэж, Майдар эргэж цам бүжиглэж эхэлсэн юм байна. Засаг Базарвааний үед 1891 онд Хайлан эхэлж хурсан байна. Мөн 1916 онд Жүд ламын сургууль эхлэн тогтоожээ.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Хөгшчүүлийн ярьснаар бол 700 лам хуварга байсан гэж ярьдаг юм билээ. Түүхийн баримт бичгээр 1920-1930 оны үед цагааны оросын эрх мэдэлд ороод лам нар цуглаад ингэсэн үед бол 320-иод лам шавилан сууж байсан юм гэнэ лээ, бусад нь хөдөө гараад явчихсан.

Асуулт:-Ойр хавьд тахилгатай уул овоо байна уу?

Хариулт:- Тахилгатай газар гэвэл Ловонгийн нүрүүны цагаан орой байна. Зүүн талын түүш хүрэн уул бий шүү дээ. Энэний орой цагаан орой гэж байдаг юм, тэр оройг энэ хүрээний лам нар очиж тахидаг байсан юм гэнэ лээ. Яваад гарсан зам, жимтэй. Морь малаа тавиад явган алхаад гардаг замтай. Дээр нь овоо тогтсон юм байдаггүй, байгалийнхаа юунд дээж юу өргөдөг байсан болов уу, тун бага шиг овоотой доо, тийм том овоо байдаггүй юм.

Асуулт:-Яаж тахидаг байсан юм бол?

Хариулт:-Тахилгыг нь нарийн мэдэхгүй юм.

Асуулт:-Хэдэн сарын үед тахидаг байсан бэ?

Хариулт:-Зуны улиралд тахидаг байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Наадам хийдэг байсан уу, овоо тахиад?

Хариулт:-Овоо тахиад нэг их наадам хийж байсныг мэдэхгүй юм. Манай хүрээний тахилгатай газар гэж ярьдаг юм байна лээ.

Асуулт:-Нуур могой хийдийн их ламын нэр алдрыг мэдэх үү?

Хариулт:-Хамба лам нь Яримпил гэж хүн байсан юм.

Асуулт:-Хэдэн оны үед байсан?

Хариулт:-37 оны үед байсан юм шиг байгаа юм. Яримпилийн хамгийн сүүлчийн гадаалж байсан газар гээд манай Алтангадас байгаа энэ нутагт Алаг толгой гэж газар байдаг юм. Тэр Алаг толгой 57 онд анх эхлээд Алтангадас нэгдэл гээчийг байгуулаад, одоо тэр манай хүрээний хамба Яримпил гэдэг хүний гадаалж байсан, ер нь нутаглаж байсан нутаг байгаа юм, энд хуралдъя гэж тэр Алтангадас нэгдлийг байгуулахад тэр Алаг толгой дээр анхны хурлыг хийсэн гэж байгаа шүү. Тэр хамба лам Яримпилийн юу бас их өгөөжтэй газар байгаа юм, цаашдаа их өөдлөн дэвжихэд хэрэгтэй гэж тэр хүний буурь буудлыг бараадаж анхны хурлыг хийсэн. Тэрний олуулаа авахуулсан зураг эд нар ч байж байгаа. Ийм түүхтэй байсан гээд маш олон хүн зургаа авахуулсан ийм зураг над байдаг юм.

Асуулт:-Өөр том лам нарын нэр алдрыг мэдэх үү?

Хариулт:-Том лам нар Өвгөн Шунлайв багш гэж том лам байсан юм гэнэ лээ. Чойрын лам байсан юм гэнэ лээ, мундаг хүн байсан гэсэн. Наваан зурхайч, Шударга лам Цоохор хэмээх Дорж гэж хүн байсан юм байна. Давар гэж мундаг хүн байсан байгаа юм, Лхагва гавж гэж хүн байсан байгаа юм. Иймэрхүү том том улс байжээ.

Асуулт:-Чойрын ном үзээд гэвш, гавжийн зиндаа барьдаг байсан газар уу?

Хариулт:-Тийм гэнэ лээ.

Асуулт:-Энэтхэг, Төвдөөс лам нар байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Энэтхэг, Төвдөөс байгаагүй юм байлгүй, харин Энэтхэг, Төвд явсан улсууд байсан бололтой юм шиг байна лээ. Манай өвгөн аав болох юм даа Баатар вангийн хошууны бичээч хийж байсан Балдан гэж хүн байсан юм гэнэ лээ, тэр хүн бол лав энэ Төвд рүү яваад ном үзээд ирсэн хүн гэж байгаа юм. 3 жил болоод ирсэн хүн гэж байгаа шүү. Тэгэхээр энэ юунд ороогүй тийм хүн байж байхыг бодоход энэ улсуудаас ямар ч байсан Төвд рүү явж суралцсан байхаа, мэдэж ирсэн байх гэж бодож байгаа шүү.

Асуулт:-Энэ хүрээнд улааны урсгалын лам нар байсан уу? жод лүйжин тавьдаг ч юмуу?

Хариулт:-Тэрнийг ёстой мэдэхгүй юмаа. Лүйжин тавьдаг хүн байсан юм гэнэ лээ шүү манай энд.

Асуулт:-Тэгвэл улааны урсгал байсан байх нь.

Хариулт:-Одоо тэр зод тавих гэдэг мөн биз дээ. За тэгвэл ийм түүхтэй. Манайд нэг зод тавьдаг зодоч лам гэж байжээ. Тэгсэн чинь хэн гэдгийг мэдэхгүй юм. Манай энэ зодочийн хүнхэр гэж байна л даа. Энэ зодочийн хүнхэр одоо би зод тавиадахъя гээд нэг нөхрөө дагуулж ирж зод тавьсан чинь ганц өөрийн нь баастай ходоод үлдэж байсан гэдэг юм. Тэгэхээр юм идээд уугаад дуусахад ганц ходоод үлдэж байсан. Тэгэхээр нөгөө сахилгагүй хүн чинь ходоод руу нь хөөргөө хийчихсэн. Ахиад яагаад байсан чинь нэг жаахан царай муутайхан шиг болсон. Та яав гэсэн чинь мань хүн дотор жаахан хүйтэн оргиод байх юм гэж. Тэгээд эргээд та тэр номоо айлдахгүй юу гэхээр буцаад хэвийн болохоор зэрэг хөөргөө авчихаж байсан юм гэнэ лээ гэж тийм домогтой. Тэгээд одоо зочдын хүнхэр нэртэй. Тэр бол зодочийн хүнхэр гэж байгаа. Тийм газар байдаг юм. Тэгэхээр улааны урсгал байсан гэж үзэх үндэс байна.

Асуулт:-Эмэгтэй лам нар байсан уу?

Хариулт:-Эмэгтэй лам нар гэж мэдэхгүй юмаа. Бас нэг ийм яриа байдаг юм. Манай хүрээний нярав хүнийг юу гэдэг юм бэ? Жасын нярав Гүнбэн гэдэг хүн байсан юм гэнэ лээ. Тэр цагааны оросууд баригдаад ингээд байж байсан. Тэгээд нөгөө түлхүүрээ авч алга болчихоод бүр эрэл хайгуулж болж байж араас Элсний худгийн эндээс олж авсан юм гэнэ лээ. Бүр энэ элсний ард талаас.

Асуулт:-Цагаантнууд ирээд лам нарыг нь устгачихаад

Хариулт:-Тийм, лам нарыг нь устгачихаад тэгээд гол хүн алга болчихсон.

Асуулт:-1930-аад оны үед

Хариулт:-19, 20-иод оны үед байгаа байлгүй дээ. Жасын няравыг нь олоод наашаа явж байсан чинь 4 орос барьж аваад явж байж л дээ, тэр хүнийг. Тэр Гүнбэн гэдэг хүнийг. Тэрнийг барьж аваад явж байсан чинь их бороо орж. Тэгэхээр зэрэг нөгөөдүүл чинь цуваа нөмөрч буугаа босгож тавьчихаад унтаж. Нөгөө хүн чинь барилддаг байсан тэнхээтэй хүн юм л даа. Тэгээд бороо их ороод хороод ирэхээр зэрэг биеэ жаахан суллаад байсан нөгөө сур чинь тайлагдаад байсан. Тэгж байгаад босч ирээд бүүгий нь аваад бүүдчихвал яадаг юм бол гэж бодож байснаа болиод нэг нэг толгойд нь цохичихвол яадаг юм бол гэж нэг бодсоноо үгүй ер нь болмооргүй юм шиг санагдаад тэгээд нэг эмэгтэй Дарь эх гэсэн байхаа би энэ Солжирийн уул руу явахад амьд гарах юм байна гээд залбирч. Тэгээд амьд гарч ирж байсан юм гэдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цагаан оросууд эхэлж орж ирэхэд ингэжээ. Манай Баатар ван ноён зүүн тийшээ хот хүрээ орохоор явах замдаа энэ Тэргэн замын аманд хөндий том гэр барьж, манай энд аюул гамшиг тохиолдож мэдэх нь байна шүү, намайг иртэл энэ гэрийг авч болохгүй шүү гэж хэлсэн юм билээ. Тэгээд том ханхай гэр бариад, дотроо юу ч үгүй ийм гэр Тэргэн замын амны адаг дээр бариад явжээ. Нэлээн их удаж. Нөгөө гэр нь бороо шороонд норох барих, янз бүрийн юм бас муудах тийм байдал гарсан юм байлгүй. Хоёрын хооронд гэр бариад яах вэ, энэ гэрийг ерөөсөө хурааж авъя гээд хурааж авсан юм гэнэ лээ.

Тэгээд нэг өглөөгүүр Тэргэн замаар уруудаад баахан адуу хөөсөн морьтой хүн ороод ирэх шиг болсон юм гэнэ лээ. Тэгсэн чинь дөрөөн дээрээ өндийгөөд боссон чинь баахан морьтой хүн ирж явна. Тэгэхэд манай авга ах лам хүн тэр хүрээн дээр байсан юм гэнэ лээ. Шоовой гэдэг хүн. Тэгээд багш нь ийм ийм юм боллоо яахав гэсэн чинь. Энэ ч хэцүү юм болно доо, түргэн л арга хэмжээ авахаас, яаж ийж гарах арга байна уу, үгүй юу гээд зурхай зураад байсан юм гэнэ лээ, багш нь. Тэгээд нөгөө хүрээг чинь алсуур бүсэлж аваад, тэгээд ойртож иржээ. Их олон ч хүн ирээгүй юм гэнэ лээ. Нөгөө лам нарыг чинь бөөгнөрүүлж хурал хийсэн юм гэнэ лээ.

За тэгээд хурал хийжээ. Хурал хийгээд яасан. Манайх та нарыг 3 давхар бүсэлсэн. Та нар ерөөсөө нэг хашаандаа төвлөр, ус цас энээ тэрээ юм авахаар болбол гадагш нь гардаг бичиг зөвшөөрөлтэй гаргана, хоол ундаа дотроо зохицуул гэж эхлээд их найрсагдуу шаардлага тавьсан юм байна лээ. Гадна тийшээ гарч болохгүй гэж. Манайх 3 давхар бүсэлсэн байгаа шүү гэж. Тэгээд усанд гаргадаггүй, тэр булгаасаа ус авдаг хэдхэн хүн томилсон юм гэнэ лээ. Хоёр сав ус бариад ирэх тийм дайны улсуудыг сонгож авсан юм билээ. Тэр улсууд дотор нь манай авга ах Шоовой гэдэг хүн оржээ. Тэгээд 2 дашмаг ус аваад. Цагаан цэргүүд бүсэлчихсэн байж байгаа.

Тэгээд хашаан дундуур гараад явахдаа өөрийнхөө байр луу ордог хүрээ хийдийн хайрч барьсан боов ч байдаг юмуу, тийм юмнууд байдаг байсан байгаа юм. Тэгээд тэрнээсээ нэг дашмагандаа чихэж аваад, нэг дашмагандаа ус хийж аваад ингэж орж ирж нэлээн өлсгөлөндөө байсан гэж байгаа. Тэр хооронд бас дотор нь муу хүн яваагүй юм болов уу, нэг хүн тэр жасын юунаас уут цагаан будаа давуулж өгсөн юм гэнэ лээ. Уут цагаан будаа давуулж өгсөн, тэрүүгээр бид нар өл залгасан даа гэж ярьдаг юм билээ. Бас дотор нь тийм сайхан сэтгэлтэй хүн байсан юм байна лээ гэж ярьдаг байсан.

Тэгээд манай нутгийн нэг хулгайч хүн байж гэнээ, нэг сайн эр. Их ч сайн эр байсан юм гэнэ лээ, ойр зуурын айл хунарын жаахан юм хулгай хийдэг. Завханд Оросууд явж байхад нэг орос эхнэр нь шархдаад тэгээд хувцасыг нь хаана тавьчихсан байсан юм, нөгөөдөхийг нь хулгай хийж ирээд тэгээд энэ хүрээний аргал дотор хийгээд булчихсан байсан гэсэн. Тэрнийг яаж илрүүлсэн гэхээр улсууд хүрээ хийдийн орчмыг нарийн ажиглаад байсан чинь аргал дотроо юм булчихсан байсныг олсон юм гэнэ лээ. Тэгээд нэг аргал дотроос мөнгөн аяга юу байдаг юм тийм үнэт эдлэлүүд олсон байгаа юм. Улсууд юмнаас дайжаад бас юмаа нуучихсан байсан байна л даа. Тэгээд мөнгөн аяга олсон учраас хэд хэдэн аргал үхсэн бас зохих хэмжээний юмнууд олжээ. Ахиад нэг аргал үхсэн чинь нөгөө орос эхнэрийн хувцас олдсон байгаа юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Танай хошууны хулгай хийдэг нөхөр хулгай хийж авчраад аргалан дотроо хийчихсэн юмуу?

Хариулт:-Тийм. Тэгэхээр зэрэг энэ чинь Торгон баатар вангийн хүрээ гээд байсан чинь тэр Хатанбаатарын хүрээ мөн юм байна. Хатанбаатар Магсаржав гэдэг чинь бид нарыг дарж сөнөөгөөд сүйдэлж яваа хүн. Яах аргагүй тэрний хамсаа сүлбээтэй улсууд нь мөн учраас Завханд шархдаад байж байсан хүний хувцас маань энд ирчихсэн байж байхыг бодоход яах аргагүй сүлбээтэй хүн байна гэж асууж байцааж байсан юм гэнэ лээ, улсуудыг.

Асуулт:-Тэр лам нарыг.

Хариулт:-Тийм. Тэгээд манай тэр авга ахыг товчоог ташуур гэж ярьдаг юм, одоо миний бодлоор бол тийм сүлжчихсэн, сүлжмэл ташуур байсан байх. Тэрүүгээр нь ороолгож байгаад асуугаад байдаг байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Тэр цагаан оросууд?

Хариулт:-Тийм. Тэгэхэд манай хүн ингээд хэлчихсэн юм гэнэ лээ. Иди меня нет гээд. Яагаад тэгж хэлсэн юм гэхээр зэрэг манай энэ хүрээнд Иван орос гээд нэг орос байж. Тэр оросуудтай энэ хүрээнийхэн ч холбоотой, сүлбээтэй, аан уун гэдэг.

Асуулт:-Наймаачин орос юмуу?

Хариулт:-Тийм. Наймаачин орос байсан юм байна л даа. Оросын пүүс байсан юм гэнэ лээ. Тэгээд тэр хүний хэлдэг үгийг ингээд юу ч учир мэдэхгүй хэлчихсэн юм байгаа юм. Тэгэхээр зэрэг юу гэж ойлгосон юм, маш их зодсон юм гэнэ лээ. Тэрнээс түрүүн нэг хүн ороолгосоор байгаад алсан юм гэнэ лээ. Эхний хүнийг алахдаа ташуураар ороолгосоор байгаад алсан гэж ярьж байна лээ.

Асуулт:-Лам хүнийг үү?

Хариулт:-Тийм. Нэг ламыг. Тэгээд манай авга ахыг ороолгож ороолгож бүр янзын юм хийж аваад тэгээд арайхийж нэг тавьсан. Орой нь багшаасаа асууж, би яавал зохилтой вэ? Ингэлээ гэсэн. Яах ч арга байхгүй, чи оргож гарах нэг зам байна чамд, тэгэхгүй бол удахгүй чамайг ташуураар алсан шиг чамайг алах юм байна. Чи ямар байдлаар оргож гар. Чамд би оргож гарах нэг арга зааж өгье. Яах юм гэхээр нүцгэл. Нүцгэлээд хувцсаа жаахан ийм эрүүн дороо таарсан юу хийж аваад нүцгэн мөлөх. Харанхуй болохоор зэрэг мөлөх. Тэгээд амьд гарч магадгүй гэж хэлсэн юм гэнэ лээ. Эхний шөнө тэгж боож мөлхөж гараад гэрэл гэгээ тусахаас нааш эргэж орж ирсэн юм гэнэ лээ. Дараагийн шөнө нь явжээ. Ямар ч байсан нэг хоёр бүслэлтээс гарчихав уу гэж болоод байсан. Тэгсэн чинь морьтой хүн давхиад ирлээ гэнэ, харанхуй дундуур. Бөөгнөөд унтчихсан ч байсан юм болов уу, мэдэхгүй. Тэгээд хүрээд ирсэн чинь Эрхийн Халтархүү гэдэг хүн байж гэнээ, нутгийн хүн байж. Тэгсэн тэр хүн маань Да хүрээ хийдээр аллага таллага их болж байна, авч яачихаар ашиг байна уу? гэж асууж гэнэ. Олз ашиг ч муухан байхдаа, аллага ч эхэлчихлээ. Ерөөсөө гадагшаа гарахаас өөр замгүй гэж. Тэгэхээр зэрэг манай авга ах чинь тэр жаахан хувцсаа хийчихээд нүцгэн цаашаа мөлхөөд явсан. Нөгөөдөх гүн рүү орсноо удалгүй эргээд давхиад ирсэн. Ер нь орох шинж алга, тэнд нэг бөөн хар юм харагдаад байх юм, тэр лүү нэг оччихоод ирье гээд нөгөөдөх рүү явсан чинь нөгөө харуулаад бүслэлтийн улсууд нэг хэсэг нь бөөгнөрөөд унтчихсан байсан байхгүй юу. Нөгөөдөх нь мэдээд өндийнгүүт наашаа давхиж ирээд манай тэр авга ахыг араараа их чадалтай ч хүн гэнэ

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

лээ, ганцхан гараараа базаж ардаа сундлуулчихаад тэгээд хойшоо Бэрхийн уул чиглээд давхичихсан гэнэ лээ. Давхисаар байгаад хамгийн давчуу ам руу ороод нэг айлд хүрээд ирсэн ганц бие чавганц байсан байгаа юм. Нөгөө чавганц нь хаданд гараад нуугдчихсан. Тогоотой сүү нь яг ингээд дэврэх гээд өөдөө хөөрөөд гараад ирж байсан гэж байгаа. Тэгж амьд гарсан гэж ярьдаг юм билээ.Цагаантны явдлаас ганц нэг түүх тэр байна.

Асуулт:-Барилга, дуганыг нь яаж барьж байсан, монголчууд барьж байсан уу?

Хариулт:-Монголчууд барьсан юм гэнэ лээ.

Асуулт:-Түүхий тоосго уу?

Хариулт:-Тоосго нь түүхий тоосго юм шиг байна лээ, ингэдэг юм байна лээ. Энэний улаан дуган гээч юмыг манай нэг авга ах л Дагвасүрэн гэж одоо тэр Шоовойн дүү авга ах тэр хүн дархан, мужаан хүн байлаа. Тэр хүнд нэг чи байсан юм. Модон чи байсан юм.

Асуулт:-Чи гэдэг чинь юу гэсэн үг вэ?

Хариулт:-Чи гэдэг чинь өнцөг хэмжигч. Тэр модон чи болохоор зэрэг манай энэ хүрээний Улаан дуганыг барихад хэрэглэсэн чи байгаа юм гэж ярьдаг байсан юм.

Асуулт:-Хэдэн оны үед Улаан дуганыг барьсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Дандаа монголчууд барьсан?

Хариулт:-Ямар ч байсан сүүлийн барилга бол монголчууд барьсан байхаа. Улаан дуган гээч юмыг барихад манай аав эд нар Улаан дуган энд байсан, өөрсдийнх нь хөгшчүүл байсан болоод ч тийм идэвхтэй байдаг юмуу, тэр Улаан дуганы үүднээс шороо ч авдаг, Улаан дуган гэж ярих дуртай улсууд юм шүү дээ.

Асуулт:-Цагаан оросууд лам нарыг нь хороогоод бурхан шүтээнийг нь байхгүй болгоод, жасын алт мөнгийг нь дээрэмдээд?

Хариулт:-Тэрнийг ингэж ярьж байгаа юмаа хөгшчүүд. 200 орчим хүн байсан юм болов уу, нөгөө хүрээний лам юунуудаас нэхээд байсан юм гэнэ лээ. 200 мөнгөн аяга гаргаж өг, 200 хом ширдэг тэмээтэй бэлдэж өг гэж ярьж байсан юм гэнэ лээ. Тэгэхээр 200 мөнгөн аяга гэдэг нь 200 хүн орж байсан болов уу, 200 цэрэг орж ирсэн байх. Тэгээд 200 хом ширдэг тэмээтэй бэлдэнэ гэдэг чинь хүн болгон нэг нэг тэмээ хөрөнгөтэй явах байсан болов уу гэж ярьж байгаа. Тэгээд тэр хом ширдэг бэлдээд байсан юмыг чинь сүүлд нь араас нь яагаад ирэхээр зэрэг говьд тараагаад хаячихсан байсан юм гэнэ лээ. Тэгж ярьдаг байсан юм.

Асуулт:-Энэ хүрээн дээр Ганжуур, Данжуур гээд том судрууд байсан уу?

Хариулт:-Байсан гэнэ лээ. Ганжуур байсан. Ганжуурт очиж мөргөдөг байсан гэж улсууд ярьдаг юм. Ганжуурыг чинь нутаг тойрон гороолдог байсан юм гэнэ лээ. Тэмээнд ачаад яадаг. Тэрнийг нь улсууд идээ будаатай тосч очиж мөргөж, жигтэйхэн юм болдог байсан юм гэнэ лээ. Тэр бол маш хүндэтгэлтэй хүлээж авдаг, нутгаа тойроход бол ерөөсөө нутаг ус усаараа яадаг. Хамгийн хүндэтгэлтэй юм тэр байсан гэж тэгж ярьдаг юм шүү.

Асуулт:-Ном судраа барладаг бар байсан юм болов уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Маш их бар байсан юм. Сая Залгадын байшин гэдэг дээр асар их бар байсан тэрнийг авч үлдэлгүй яасан хайрхан юм даа. Миний ойрын үзсэнээр маанийн бар. Тэр миний үзэж хэрэглэж, маанийн барын дор хоёр хүрд хийсэн байгаа юуны хажууд. Тэрнийг манай энэ Нуур могой хүрээнд сууж байсан Аюушийн Данж гээч хүн хийсэн юм, тэр хүрдийг. Тэр хүрдний нэг нь алга байна лээ. Нэг нь байна лээ, нэгийг нь аваад хямгадчихсан юм байлгүй гэж ойлгож байгаа. Тэр барыг яахад би ч гэсэн барлаж л байсан юм даг. Тэрнээс гадна номын маш их бар байсан юм.

Асуулт:-Тэгээд байхгүй болсон уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Голлох бурхан шүтээн нь юу байсан юм?

Хариулт:-Лхам бурханыг л, ерөөсөө Лхам тахилгатай, Лхам бурхан гэж ерөөсөө яригддаг юм. Би энэ урд хүрээний юунд бас хоёр юм хэлээдэхье гэж бодож байна.

Асуулт:-Ямар хийд?

Хариулт:-Вандантэгчилэн хийдэд энд их чадалтай бурханч лам нар байсан гэж ойлгоод байгаа. Бурхан бүтээдэг лам нар. Жишээ нь, энд нэг ийм хүн байсан гэнэ. Зурхайч Жамбал, зураач Жамбал гэж ерөөсөө нэг л хүн юм байна л даа. Зурхайч ч зурдаг, зураач ч зурдаг. Тэр хүн болохоор их бурхан бүтээдэг байжээ. Одоо энэ манай сумын урд талд өнгөн шороо гэж байдаг юм. Тэр өнгөн шороог 7 тунгаагаад бурхан зурж байсан юм гэнэ лээ. Тэрний өөрийн нь ширээ эд нар дээр тавиад хээлээд байж байсан хээтэй ширээ айлд байж байсан. Одоо чухам байна уу, үгүй юу мэдэхгүй. Удам залгасан нэг хүүгийн д нь байсан юм. Тэр бол маш гоё. Тэрний бүтээсэн бурхан нь аймгийн музейд байгаа. Тэрний ном юуны хэрэглэл нь байгаа. Зураг авбал би тэр дээрээс та нарт бурханы зураг авч үзүүлье. Тэрнээс гадна Жамбал зураач гэж хүн тийм бурхан зурж, бурхан бүтээдэг бурханч лам байжээ. Тэрнээс гадна Довдон гэж нэг хүн байж.

Асуулт:-Урд хүрээний?

Хариулт:-Тийм.Урд хүрээний Довдон гэж хүн байж. 1951 оны орчим тахлаар нас барсан хүн. Тэр хүн гайхалтай бурхан бүтээж. Одоо би та нарт ёстой юун дээрээс тэрний гоё юмыг үзүүлнэ дээ. Тэр хүн бол асар олон бурхан бүтээсэн. Хамгийн сонирхолтой, хамгийн гоё юм нь болохоор зэрэг 9 эрдэнээр ном бүтээсэн. Одоо энэ уламжлал болж хадгалагдаж байгаа улсуудад нь байна. Тэр зургийн хэрэгслүүд нь, хулсан үзэг нь байна, гортиг нь байна, шугам нь байна, шугам нь байна. Тиймэрхүү юмнууд байна шүү, тиймэрхүү нарийн юмнуудыг үзүүлье, зургийг нь авахуулъя.

Тэрнээс гадна Нуурмогойн хүрээн дээрээс баригдаад явсан нэг хүний хувцас, хэрэглэл байна. Номын хувцас байна. Доод талын юу болохоор зэрэг баригдаад явснаас нь хойш бага 4 ханатай гэрийн хөшиг хийхэд тойрч байсан юм гэнэ лээ, тийм том хүн байсан юм гэнэ лээ. Хүн нь том хүн байсан юм гэнэ лээ. Тийм хоёр юм үзүүлж болж байна.

Асуулт:-Өөр та энэ урд хийдийн талаар мэдэх юм байна уу? Том лам нар тийм тийм лам байсан гээд?

Хариулт:-Энэ хийдийг Шаравын хийд ч гэж сүүлийн үед нэрлэгдэж байсан юм байна лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Вандантэгчилэн хийд гэж, Шавар гэдэг нэртэй газар байсан юмуу?

Хариулт:-Тийм. Шавар ламын хүрээ гэдэг юм, хөгшчүүл болохоор Шавар ламын хүрээ, Баатар вангийн хүрээ гэдэг ингээд ерөөсөө хоёр.

Асуулт:-Шавар ламын хүрээ нь Вандантэгчилэн хийд?

Хариулт:-Тийм. Энэ яагаад Шавар гэсэн юм гэхээр хөгшчүүд ингэж яриад, энэ Шавар ламын хүрээний хамба хувилдаг хүн байсан юм гэнэ лээ гэж ярьдаг юм билээ. Тэгээд ингээд биеэ муудаад ирэхээр зэрэг шавраар биеэ бүрчихдэг, тэгээд л яачихдаг, тийм хувилдаг хүн байсан юм гэнэ лээ гэж хөгшчүүл ярьж байхыг нь бүр багад сонсож байсан.

Асуулт:-Хэн гэдэг хүн бэ?

Хариулт:-Тэрнийг нэрийг нь мэдэхгүй. Багад сонсож байсан юм чинь зарим юм нь таллаж хоцроод, зарим юм нь алга болчихоод байх юм байна шүү дээ. Хурал номын голлох дацан нь Чойнхорлон дацан гэж байсан юм байна даа. 20-30-аад оны үед 198 орчим ламтай байсан гэж бичигдсэн байдаг юм байна лээ. Чандмань хайрхан уулын түшиц газар олон зуун жил оршин тогтнож байсан. Одоо Чандмань уулын шүтлэгтэй байсан тийм газар юм билээ.

Асуулт:-Тахиж байсан, Вандантэгчилэн хийд үү?

Хариулт:-Тийм. Бас Еншүү хүрээ ч гэж нэрлэдэг. Энэ дээд тал чинь хоёр янзын Еншүү байдаг юм шүү дээ. Нэг нь зүгээр еншүү, нэг нь огтор еншүү гэж.

Асуулт:-Еншүү гэж юу гэсэн үг юм?

Хариулт:-Еншүү гэдэг чинь хурдан морь уралдаад морины сүүл боодог шүү дээ. Тэгээд тэрний сүүлийг нь боогоод яасан чинь.